



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нэр дээрх)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 79,000,000.00 (далан есөн сая) төгрөгийн балансын үнэ, 40,158,331.78 (дөчин сая нэг зуун тавин найман мянга гурван зуун гучин нэгэн төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001222

6-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 01 дугаар сарын 07 өдрийн
 22 дугаар тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Хьюндай соната LF, УБУ 38-99 (арал- КМНЕ241СВКА510777)	2019/2020	79,000,000.00	40,158,331.78	38,841,668.22
	Нийт дүн		79,000,000.00	40,158,331.78	38,841,668.22
			(далан есэн сая)	(дөчин сая нэг зуун тавин найман мянга гурван зуун гучин нэгэн төгрөг далан найман мөнгө)	(гучин найман сая найман зуун дөчин нэгэн мянга зургаан зуун жаран найман төгрөг хорин хоёр мөнгө)